



БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



МАЛ ТООЛЛОГО-2018



2019 он

ОРШИЛ

Монгол улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн хэмээн томъёолж, энэ ч утгаараа мал тооллогын ажлыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Статистикийн тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүд жил бүрийн 12 сарын 7-17 өдрүүдэд “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ыг зохион байгуулж явуулдаг билээ.

Үүний дагуу дүүрэгт 2018 оны тооллогыг нийслэлийн Засаг даргын А/1116 тоот захирамж, дүүргийн Засаг даргын А/449 тоот захирамжаар энэ оны мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого явуулах ажлын хэсэг, тэдний ажиллах удирдамжийг батлуулан тооллогын хугацаанд амжилттай зохион байгуулж явууллаа.

Мал тооллогын дүнг нэгтгэсэн энэхүү судалгаа нь дүүргийн мал аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд суурь мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх: Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болгож байгаа өрхийг хэлнэ.

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Таван хошуу малыг бодод шилжүүлэх коэффициент:

- 1 тэмээ – 1.5 бод
- 1 адуу – 1 бод
- 1 үхэр – 1 бод
- 6 хонь – 1 бод
- 8 ямаа – 1 бод

Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент:

- 1 тэмээ - 5 хонь
- 1 адуу - 7 хонь
- 1 үхэр - 6 хонь
- 1 хонь - 1 хонь
- 1 ямаа - 0.9 хонь

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

- Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай
- Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай
- Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай
- Бог мал /хонь, ямаа/-тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал:

- Тэмээ - Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай
- Адуу - Өнгөрсөн жилийн төл, 2 настай
- Үхэр - Өнгөрсөн жилийн төл

Төл мал: Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцангуй үзүүлэлтүүдийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт болон худалдаж авсан, шилжиж ирсэн

мал, зарлага тал нь худалдсан, шилжүүлсэн мал болон хэрэглээний зарлага, том малын зүй бусын хорогдол болно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

- 1 Буур – 20 ингэ
- 1 Азарга - 10 гүү
- 1 Бух - 25 үнээ
- 1 Хуц, ухна – 50-60 эм хонь, эм ямаа

Малын зүй бусын хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түмэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон малын тоог, оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын хэрэглээний зарлага: Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Малын хашааны хангамж: Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямаа/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж: Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент: Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд доорхи

- | | |
|-------------------------|--|
| • Хадлан өвс | 0.45 |
| • Таримал тэжээл | 0.35 |
| • Даршны ургамал | 0.25 |
| • Гар тэжээл, хужир шүү | 1.0 |
| • Үр тарианы хаягдал | 0.9 |
| • Лай | 0.4 |
| • Сүрэл | 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ. |

Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал орох бөгөөд бүүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна. Үүнд:

- Бүдүүн тэжээл - өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс
- Хүчит тэжээл - үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг
- Шүүст тэжээл – Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал

Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн яс, цусны гурил зэрэг орно. Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО: 2018 оны мал тооллогоор хувийн малтай 728 өрх, үүнээс 559 өрх мал аж ахуй эрхэлж байна. Үүнийг өнгөрсөн онтой харьцуулахад:

Хүснэгт 1. Малтай, малчин өрх, хороогоор


		2015 он	2016 он	2017 он	2018 он
Нийт мал бүхий өрх	1-р хороо	149	163	150	166
	2-р хороо	78	78	81	80
	3-р хороо	170	168	166	155
	4-р хороо	160	177	170	186
	5-р хороо	118	138	145	144
Дүүргийн дүн		675	724	712	728
Үүнээс: Малчин өрх	1-р хороо	66	77	89	95
	2-р хороо	62	70	75	80
	3-р хороо	64	76	57	93
	4-р хороо	83	99	130	174
	5-р хороо	58	77	86	117
Дүүргийн дүн		333	399	437	559

2018 оны байдлаар хувийн малтай 728 өрх байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 16 (2.2) өрхөөр өссөн байна. Мөн мал аж ахуй эрхэлж, малын ашиг шимийг амьжиргааны эх үүсвэрээ болгон амьдарч байгаа малчин өрх 559 байгаа нь өнгөрсөн оноос 122 (27.9) өрхөөр өссөн байна.

Хүснэгт 2. Малтай болон малчин өрхийн ам бүл, малчдын тоо

		2015 он	2016 он	2017 он	2018 он
Нийт мал бүхий өрх		675	724	712	728
Түүний ам бүл		2305	2433	2389	2513
Үүнээс: Малчин өрх		333	399	437	559
Түүний ам бүл		1138	1336	1465	1911
Малчдын тоо		571	672	649	797
16-34 насны		136	126	152	194
35-аас тэтгэвэрт гарах насны		336	405	335	420
Тэтгэврийн насны		99	141	162	183
Нийт малчдаас эмэгтэй		232	302	277	323
Насны бүтэц					
16-34 насны		23.8	18.8	23.4	24.3
35-аас тэтгэвэрт гарах насны		58.8	60.3	51.6	52.7
Тэтгэврийн насны		17.3	21.0	25.0	23.0

Зураг 1. Малчдын тоо /насны бүлгээр/



Мал аж ахуйн салбарт 797 малчин ажиллаж байгаа бөгөөд насны бүлгээр авч үзвэл 24.3 хувь нь 16-34 насны, 52.7 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах насны, 23.0 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Нийт малчдын 323 нь буюу 42.7 хувь нь эмэгтэй малчид байна.

МАЛЧДЫН СОЁЛ, АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ:

Зураг 2. Ахуй соёлын үзүүлэлт



Нийт малчин өрхийн:

489 өрх буюу 87.5 хувь нь цахилгааны эх үүсвэртэй

425 өрх буюу 76.0 хувь нь зурагтай

392 өрх буюу 70.1 хувь нь сансарын антентай

196 өрх буюу 35.1 хувь нь радиотой

193 өрх буюу 34.5 хувь нь оёдлын машинтай


129 өрх буюу 23.1 хувь нь хөлдөөгчтэй

МАЛЫН ТОО, БҮТЭЦ: 2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр мал сүргийн тоо 184337 толгойд хүрч, өнгөрсөн оноос 12288 толгой малаар буюу 7.1 хувиар өссөн.

Хүснэгт 3. Малын тоо, төрлөөр

	2015 он	2016 он	2017 он	2018 он	2018/2017	
					зөрүү	хувь
Тэмээ	203	209	224	203	-21	-9.4
Адуу	11665	14043	13391	14652	1261	9.4
Үхэр	12319	14198	14563	15866	1303	8.9
Хонь	80103	91271	88526	92757	4231	4.8
Ямаа	50693	59053	55345	60859	5514	10.0
НИЙТ МАЛ	154983	178774	172049	184337	12288	7.1

Зураг 3. Малын тоо, оноор



Энэ жилийн тооллогоор тэмээн сүрэг 21 толгой буюу 9.4 хувиар буурч, адуун сүрэг 1261 толгой буюу 9.4 хувиар, үхэр сүрэг 1303 толгой буюу 8.9 хувиар, хонин сүрэг 4231 толгой буюу 4.8 хувиар, ямаан сүрэг 5514 толгой буюу 10.0 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 4. Малын орлого, зарлага, төрлөөр

	Орлого			Зарлага				Зүй бус хорогдол
	Худалдаж авсан,	шилжиж ирсэн	Бэлэн тоологдсон төл	Зах зээлд борлуулсан	шилжүүлсэн	Алдсан, хулгайлагдсан	Хүнсэнд хэрэглэсэн	
Тэмээ	-	-	33	30	18	-	6	-
Адуу	445	1555	3147	1900	1133	72	558	223
Үхэр	560	1879	4421	2716	1472	35	909	389
Хонь	3469	9740	30078	22983	10004	45	4903	1026
Ямаа	2861	8039	18289	12442	6192	87	3938	951
Дүн	7335	21213	55968	40071	18819	239	10314	2589

Дээрх хүснэгтээс харахад энэ жил бэлэн тоологдсон төлөөр 55968 толгой, худалдаж авсан болон шилжиж ирсэн малаар 28548 толгой мал тус тус нэмэгдэж, харин 40071 толгой мал зах зээлд борлуулагдаж, 18819 толгой мал шилжүүлж, 239 толгой мал алдаж, 10314 толгой мал хүнсэнд хэрэглэж, 2589 толгой мал зүй бусаар хорогдсон байна.

Хүснэгт 5. Малын тооны өсөлтөнд нөлөөлсөн үзүүлэлтүүд

	2015 он	2016 он	2017 он	2018 он	2018/2017	
					зөрүү	хувь
Бэлэн тоологдсон төл	46786	51107	44960	55968	11008	24.5
Том малын зүй бусын хорогдол	1023	882	3273	2589	-684	-20.9
Хээлтэгч малын тоо	72901	82523	80759	80667	-92	-0.1
Хээл хаясан хээлтэгч	541	1221	2007	755	-1252	-62.4
Сувайрсан хээлтэгч	2532	5059	12191	7402	-4789	-39.3

Дээрх хүснэгтээс харахад энэ жил бэлнээр тоологдсон төл өнгөрсөн оноос 11008 (24.5) төлөөр нэмэгдэж, том малын зүй бус хорогдол өнгөрсөн оноос 684 (20.9) толгойгоор, хээл хаясан хээлтэгч 1252 (52.4) хээлтэгчээр, сувайрсан хээлтэгч 4789 (39.3) хээлтэгчээр тус тус буурсан нь энэ жилийн мал өссөн үзүүлэлтэнд нөлөөлсөн байна.


МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ: 2018 оны байдлаар нийт мал сүргийн 83.3 хувийг бог мал, 16.7 хувийг бод мал эзэлж байна. Нийт сүргийн бүтцэд таван төрлийн малын эзлэх хувийн жинг төрөл тус бүрээр доорх хүснэгтэнд гарган харуулвал:

Хүснэгт 6. Нийт малд эзлэх хувийн жин, төрлөөр

	2015 он	2016 он	2017 он	2018 он		
НИЙТ МАЛ	100.0	100.0	100.0	100.0	Үүнээс харахад тэмээ, адуу, үхэр сүргийн эзлэх хувь сүүлийн 4 жил харьцангуй тогтвортой байна.	
Тэмээ	0.1	0.1	0.1	0.1		
Адуу	7.5	7.9	7.8	7.9		
Үхэр	7.9	7.9	8.5	8.6		Бог малын хувьд хонин сүргийн
Хонь	51.7	51.1	51.5	50.3		эзоэх хувь буурч ямаан сүргийн
Ямаа	32.7	33.0	32.2	33.0		эзлэх хувь өссөн байна.

Бог малын 60.4 хувийг хонин сүрэг, 39.6 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Зураг 4. Бог малын бүтэц



Энэ жил ямаан сүрэг 60859 толгойд хүрч өмнөх оноос 5514 толгой буюу 10.0 хувиар өссөн байна. Ямаан сүргийн тоо толгой болон бог малд эзлэх хувь сүүлийн 4 жил өсч байгаа нь бэлчээрийн даац болон сүргийн бүтцэд сөргөөр нөлөөлж байна.


МАЛЫН ТОО ХОРООГООР: Энэ жилийн тооллогоор 2 хорооны мал 227 толгой буюу 1.9 хувиар буурч, бусад хороодын мал 5.8 – 11.4 хувиар өссөн байна. Доорх хүснэгтэнд хороодын 2018 онд тоологдсон малыг өмнөх онтой харьцуулан өсөлт бууралтыг тоо болон хувиар харуулж байна.

Хүснэгт 7. Малын тоо, хороогоор

		2015 он	2016 он	2017 он	2018 он	өсөлт, бууралт	
						тоо	хувь
хороогоор	1-р хороо	39899	52207	42856	45357	2501	5.8
	2-р хороо	9845	11838	11964	11737	-227	-1.9
	3-р хороо	42554	43939	43683	47457	3774	8.6
	4-р хороо	40806	45843	47027	50246	3219	6.8
	5-р хороо	21879	24947	26519	29540	3021	11.4
Дүүргийн дүн		154983	178774	172049	184337	12288	7.1

ХУВИЙН /АМИНЫ/ МАЛЫН ТОО: Мал тооллогоор амины малын тоо 165442 толгойд хүрч нийт малын 96.1 хувийг эзэлж байна. Энэ нь өнгөрсөн оноос 7540 толгой малаар буюу 4.4 хувиар өссөн байна. Үүнээс 11 өрхийн 1875 толгой тавиул мал тоологдсон байна.

Зураг 5. Амины мал



Хүснэгт 8. Хувийн малтай өрх, малын тоо

Он	Малтай өрх	Бүгд	Үүнээс:					1 өрхийн дундаж мал
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
2015	675	148558	203	11440	11908	75629	49378	220.1
2016	724	172982	209	13822	13900	87135	57916	238.9
2017	712	165442	224	13076	14110	84506	53526	232.4
2018	728	178604	203	14293	15421	89090	59597	245.3

2018 оны байдлаар амины малын 33.4 хувийг ямаа, 49.9 хувийг хонь, 8.0 хувийг адуу, 8.6 хувийг үхэр, 0.1 хувийг тэмээ эзэлж байна. Мөн энэ жил 1 өрх дунджаар 245.3 толгой малтай болсон нь өнгөрсөн оноос 6.5 толгой малаар буюу 12.9 хувиар өссөн байна.



Амины малтай 1 өрхөд дунджаар тэмээ 0.3 толгой, адуу 19.6 толгой, үхэр 21.2 толгой, хонь 122.4 толгой, ямаа 81.9 толгой ногдож байна.

ХУВИЙН /АМИНЫ/ МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ: Нийт малтай өрхийн 45.1 хувь буюу 328 өрх 100 хүртэлх толгой малтай, 17.6 хувь буюу 128 өрх 101-200 толгой малтай, 24.2 хувь буюу 176 өрх 201-500 толгой малтай, 9.8 хувь буюу 71 өрх 501-999 толгой малтай байна.

Хүснэгт 9. Малтай өрхийн малын бүлэглэлт

	Өрхийн тоо		Дүнд эзлэх хувь	
	2017 он	2018 он	2017 он	2018 он
0-100 малтай	302	328	42.4	45.1
101-200 малтай	142	128	19.9	17.6
201-500 малтай	170	176	23.9	24.2
501-999 малтай	73	71	10.3	9.8
1000-1499 малтай	18	22	2.5	3.0
1500-2000 малтай	7	3	1.0	0.4
2000 дээш малтай	-	-	-	-
Бүгд	712	728	100.0	100.0

1000 ба түүнээс дээш толгой малтай өрх 25 байгаа нь нийт өрхийн 3.4 хувийг эзэлж байна. Үүний 22 өрх 1000-1499 толгой малтай, 3 өрх 1500-2000 толгой мал тоолуулсан байна. Энэ жил 2000 дээш толгой малтай өрх тоологдоогүй байна.



Амины малтай нэг өрх дунджаар 3.5 ам бүлтэй байгаа бөгөөд 1 хүнд 71.1 толгой мал ногдож байна. Энэ нь өнгөрсөн оноос 2 толгой малаар өссөн байна.

ХЭЭЛТЭГЧ МАЛ: 2018 оны эцэст 84465 толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оноос 3706 толгойгоор буюу 4.6 хувиар өссөн ба ингэ 20.3 хувиар буурч, гүү 11.6 хувиар, үнээ 11.3 хувиар, эм хонь 3.2 хувиар, эм ямаа 4.2 хувиар тус тус өссөн байна.


Хүснэгт 10. Хээлтэгч мал, төрлөөр

	2015 он	2016 он	2017 он	2018 он	2018/2017	
					тоо	хувь
Ингэ	72	73	74	59	-15	-20.3
Гүү	3813	4546	4586	5116	530	11.6
Үнээ	4946	5734	5912	6582	670	11.3
Эм хонь	38652	43929	42832	44192	1360	3.2
Эм ямаа	24608	28241	27355	28516	1161	4.2
Бүгд	72091	82523	80759	84465	3706	4.6

Хээлтэгч мал нийт малын 45.8 хувийг эзэлж байгаа бөгөөд

- тэмээн сүргийн – 29.1 хувь
- адуун сүргийн – 34.9 хувь
- үхэр сүргийн – 41.5 хувь
- хонин сүргийн – 47.6 хувь
- ямаан сүргийн – 46.9 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 6. Хээлтэгч малын тоо



БЭЛЭН ТООЛОГДСОН ТӨЛ: Энэ оны мал тооллогоор бэлэн тоологдсон төлийн тоо 55968 толгой болж өнгөрсөн оноос 11008 толгойгоор буюу 24.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 11. Бэлэн тоологдсон төл, төрлөөр

	2015 он	2016 он	2017 он	2018 он	2018/2017	
					тоо	хувь
Ботго	43	25	25	33	8	32.0
Унага	2564	2600	2214	3147	933	42.1
Тугал	3872	3970	3853	4421	568	14.7
Хурга	25693	27973	25017	30078	5061	20.2
Ишиг	14614	16539	13851	18289	4438	32.0
Бүгд	46786	51107	44960	55968	11008	24.5

Өнгөрсөн оны тооллогоор 80677 толгой хээлтэгч төллөхөөр тоологдсон бөгөөд

- хээлтэй малын орлогоор 9174 толгой мал нэмэгдэж
- хээлтэй мал 6547 толгойг зарлагдаж
- хээл хаясан 755 толгой мал
- сувайрсан хээлтэгч 7402 толгой мал тус тус хасагдаж 75145 толгой хээлтэгч төллөсөн нь нийт төллөх насны хээлтэгчийн 74.5 хувь байна.

Хүснэгт 12. Төл бойжилт, төлийн орлого, зарлага, төрлөөр

	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Худалдаж	
					авсан шилжиж ирсэн	Худалдсан шилжүүлсэн
Ботго	51	51	10	41	-	8
Унага	3954	3954	45	3909	133	895
Тугал	5392	5392	56	5336	236	1144
Хурга	40328	40351	333	40018	1165	10789
Ишиг	25420	25450	371	25079	930	7720
Бүгд	75145	75198	815	74383	2464	20556

2018 онд 75198 толгой төл хүлээн авсан бөгөөд 815 толгой төл мал хорогдож төл бойжилт 98.9 хувьтай байна. Өнгөрсөн онд 23 ихэр ишиг, 30 ихэр хурга хүлээн авсан байна.

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ: 2018 оны тооллогоор 2589 толгой том мал хорогдсон бөгөөд энэ нь оны эхний малын 1.5 хувьтай тэнцэж байгаа нь өнгөрсөн оноос 684 толгойгоор буюу 20.9 хувиар буурсан байна. Нийт хорогдсон том малын 8.6 хувийг адуу, 15.0 хувийг үхэр, 39.6 хувийг хонь, 36.7 хувийг ямаа эзэлж байна.

Хүснэгт 13. Том малын зүй бусын хорогдол, төрлөөр

	2015 он	2016 он	2017 он	2018 он	2018/2017	
					зөрүү	дахин
Тэмээ	-	-	-	-	-	-
Адуу	112	52	343	223	-120	-35.0
Үхэр	110	155	343	389	46	13.4
Хонь	431	375	1349	1026	-323	-23.9
Ямаа	370	300	1238	951	-287	-23.2
Бүгд	1023	882	3273	2589	-684	-20.9

Энэ онд хорогдсон нийт малын 929 толгой мал буюу 35.9 хувь нь гэнэтийн аюулаар, 19 толгой мал буюу 0.7 хувь нь өвчнөөр хорогдсон байна.

Хүснэгт 14. Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь

	2015 он	2016 он	2017 он	2018 он
Тэмээ	-	-	-	-
Адуу	1.0	0.4	2.4	1.7
Үхэр	1.0	1.3	2.4	2.7
Хонь	0.6	0.5	1.5	1.2
Ямаа	0.7	0.6	2.1	1.7
БҮГД	0.7	0.6	1.8	1.5

ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТОХИРОО: 2018 онд 1465 хээлтүүлэгч мал тоологдож өмнөх оноос 123 толгойгоор буюу 9.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 15. Хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо

	Хээлтүүлэгчийн тоо	Үржлийн норм	2015 он	2016 он	2017 он	2018 он
Ингэ	3	20	24	37	25	20
Гүү	561	10	9	9	9	9
Үнээ	194	25	35	33	32	34
Эм хонь	399	50	108	106	110	111
Эм ямаа	308	60	112	93	98	93

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо тэмээ болон адуун сүргээс бусад сүргийн хувьд алдагдаж байна. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 50-60 хээлтэгч ногдох ёстой атал тооллогоор хонь ямаан сүргийн хувьд 111 эм хонь, 93 эм ямаанд 1 хээлтүүлэгч ногдож байгаа нь үржлийн нормоос 1.5-2.0 дахин их байна.

БЭЛЧЭЭРИЙН ХҮРЭЛЦЭЭ: Манай дүүрэг 62020 га газар нутагтай 2018 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар 39510.4 га хөдөө аж ахуйн эдэлбэр газар байна. Үүнээс бэлчээрийн талбай 38706.1 га болсон байна. 2018 оны тооллогоор тоологдсон малын тоо хонин толгойд шилжүүлснээр 346305 болсон нь өнгөрсөн оноос 25733 толгой буюу 8.03 хувиар өссөн байна.

Зураг 7. Нутаг дэвсгэрийн хэмжээ



Хүснэгт 16. Бэлчээрийн даац

	2015 он	2016 он	2017 он	2018 он
Нийт малын тоо /хонин толгой/	282311	328953	320572	346305
Бэлчээрийн талбай	39417.8	39267.7	38710.9	38706.1
100 га-д ногдох малын тоо	716.2	837.7	828.1	894.7

Дүүргийн 100 га бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 894.7 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 66.6 толгой малаар буюу 8.04 хувиар өссөн байна.